



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цоглог хангай ХХК-ны "Титэм" зочид буудлын 16/037, Өгөөмөр алтай ХХК-ны "Өгөөмөр алтай" зочид буудлын 13/032, Мон-Тул ХХК-ны "Жи ди эл" дэн буудлын 16/028, Мөнх ариун ундарга ХХК-ны "Сац" зочид буудлын 16/034 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг

1150500231

хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг
болгосугай.

ДАРГА *D. Balt* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 07 сарын 21
өдрийн 15 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.07.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мөнх ариун ундарга ХХК	5235359	Сац	ХУД-ийн 3-р хороо Шаравын гудамж Үйлдвэр-12
2	Мон тул ХХК	2112752	Жи Ди Эл	БГД-ийн 20-р хороо Москвагийн гудамж 21
3	Өгөөмөр Алтай ХХК	2676192	Өгөөмөр Алтай	СХД-ийн 12-р хороо Саппорогийн ард Өнөр хорооллын гудамж-37/1
4	Цоглог Хангай ХХК	2542811	Титэм	СХД-ийн 14-р хороо ЭТӨЧ-105

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 04 сарын 01
өдрийн А/55 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.07.21

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Гэрэлт хүсэл ХХК	2727528	Хур	БГД-ийн 12-р хороо Хасбаатарын гудамж- 5/1

--ooOoo--